



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/338

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой байдлын газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Хөвсгөл аймагт зохион байгуулагдах онцгой байдлын байгууллагын албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, албаны бэлэн байдлыг хангуулах “Гал унтраах техник олон төрөлт бүсийн тэмцээний үйл ажиллагааны зардалд 12,000,000 (Арван хоёр сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 12,000,000 (Арван хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Зардалтай холбоотой шаардлагатай баримт бичгийг бүрдүүлж, тайлагнаж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа (Ё.Пүрэвсүрэн)- д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6713010703